

**Батлав:**

**БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга:...../Ч.БАТСАНСАР /**

**Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

**“ПЕНТАТЕРРА” ХХК-ийн гүйцэтгэх захирал...../У. СОДОО /**

**Сэлэнгэ аймгийн баянгол сумын нутагт орших МҮ-019039 тоот дугаартай “наран голын зүүн дэнж хш-102-хш-114” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**/ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР МҮ-019039/**

**Хянасан:**

**БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн:...../ /**

**Боловсруулсан:**

**“ПЕНТАТЕРРА” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн:...../ /**

**УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

<b>Хянасан огноо</b>	
<b>Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар</b>	
<b>Дүгнэлт</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Шийдвэрийн төсөл</li> <li>• Ололт, амжилттай тал</li> <li>• Дутагдалтай сул тал</li> <li>• Шаардлага</li> </ul>	

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, баганад мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

<b>д/д</b>	<b>Мэдээллийн төрөл</b>	<b>Мэдээлэл оруулах багана</b>
<b>1.1</b>	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	ПЕНТАТЕРРА ХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011223039
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	УУЛ УУРХАЙ
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Сэлэнгэ аймаг, Баян гол сум II-р баг
	5. Захирлын нэр, утас, цахим хаяг	
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Амангелди <a href="mailto:Amangeldi@sharyngol.mn">Amangeldi@sharyngol.mn</a> 99010414
<b>1.2</b>	1. Төслийн нэр	НАРАН ГОЛ
	1. Төслийн харьяаллын байршил	Сэлэнгэ аймаг, Баян гол сум II-р баг
	3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд в. баяжуулах үйлдвэр	1. Шороон орд 2. Ил уурхай
	4. Төсөл эхэлсэн огноо	2020
	5. Төсөл хэрэгжих хугацаа	2 жил
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	-
	7. Хаалтын дараах зориулалт	

8. ТЭЗҮ баталсан огноо	2022
9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	-
10. Ажилчдын тоо	50
11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	40
12. Тухайн төсөлд хамраах дэд бүтэц <ul style="list-style-type: none"> <li>• замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл;</li> <li>• шатахуун түгээгүүрийн тоо</li> <li>• шатахуун агуулахын агууламжийн хэмжээ</li> <li>• тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт</li> </ul>	ШТС -1 3 ш 100 ТН

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-г тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	013039А 2045 он 63.24 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/  Дугаар Хүчинтэй хугацаа	
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2022.03.
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2022 он

6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2022
7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	-
8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	-
9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах	
10. ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	Давхцалгүй
11. Тухайн жилд баримтлах стандартын дугаар <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний</li> <li>• Олон улсын</li> </ul>	MNS ISO 450001

**ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтад тусгагдсаныг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсаны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах

- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/

- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт **“хангалттай”** гэсэн дүгнэлтийг оруулна.

- урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- эрсдэлийн үед авах арга хэмжээ
- учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
- хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Ажилласан масло 150 тн
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “НАРАН ГОЛЫН ЗҮҮН ДЭНЖ ХШ-102-114”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.2	<ol style="list-style-type: none"> <li>Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх</li> <li>Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх</li> </ol>	
3.3.	<ol style="list-style-type: none"> <li>Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> <li>Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>Аюултай хог хаягдал</li> </ul> </li> </ol>	150 тн ашигласан масло. Ахуйн хаягдлыг сумын хот тохижуулахдаа гэрээ хийнэ.
	<ol style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв</li> </ol>	Гэрээний дагуу төлбөр тооцоо хийнэ.

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	51.0 сая
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	Үйлдвэрлэлийн зардалд тооцно 35.5 сая Тоосжилтыг усалгаа хийж дарах
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	5.0 сая
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	20.0 сая
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	5.0 сая
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	ИНХурлыг хуралдуулж, үйл ажиллагааны тайлан хэрэгжилтийг тайлагнана. 0.5 сая
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1.0 сая
	8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	Илэрсэн олдворуудыг сумын байцаагчтай хамтран үзлэг хийх. 0.5 сая
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	5.0 сая

**ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ**

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	<b>Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл</b> 1. Тосгон 2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Хог хаягдлын агуулахын байршил 5. Хог хаягдлын далан 6. Химийн бодисын агуулахын байршил 7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 8. Тухайн жилд хуулах хөрс 9. Гадаад, дотоод овоолго 10. Техникийн нөхөн сэргээлтийн талбай 11. Биологийн нөхөн сэргээлтийн талбай 12. Гүний худгийн байршил 13. Дүйцүүлэн хамгааллын байршил	

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй” “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл  - Бохирдуулах - Эвдэх		Тодорхойлсон			

- Доройтуулах					
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах		Тодорхойлсон			
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчныг хуваах - амьдрах орчныг доройтуулах - амьдрах орчныг хомсдуулах - нөөцийг бууруулах		Тодорхойлсон			
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос		Тодорхойлсон			
6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн шилжүүлэх		Тодорхойлсон			

**ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**тийм**”, “**үгүй**” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ		Тийм		
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3		Тийм	
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ		Тийм		
7.4. - Техникийн/ га эзлэхүүн - Биологийн /га	6.4 га 5.8 га			
7.5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	1.5 га	Тийм		
7.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ				
7.7 Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ		Тийм		
7.8 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ				

**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” баганд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

<b>Хяналт шинжилгээний дээж</b>	<b>А. Дээж авах цэгийн тоо</b>		<b>Б. Дээж авах цэгийн байршил</b>	<b>В. Давтамж</b>	<b>Г. Төсөв</b>
8.1. Хөрс	1		Карьер	4	1.500.000
8.2. Ус	1		Шүүрлийн ус	4	1.500.000
8.3. Амьтан					
8.4. Ургамал					
8.5. Агаар	1		Карьер	4	2.000.000

**АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
1.1. Төслийн товч танилцуулга .....	3
Уурхайн одоогийн байдал.....	4
1.2. Уулын хэсэг .....	5
1.3. Ил уурхайн ашиглалтын систем .....	7
1.4. 2021 онд явуулах уурын ажил, ажиллах горим.....	7
1.5. Уурхайн нөхөн сэргээлт.....	8
1.6. Баяжуулалтын технологи .....	8
1.7. Дэд бүтэц .....	8
<b>БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬНӨХЦӨЛ</b> .....	9
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, БУУРУУЛАХ АРГАХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ</b> .....	12
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	12
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....	12
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....	12
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....	12
3.5. Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж.....	12
<b>БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	14
<b>БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	15
<b>БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	18
<b>БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭНХАМГААЛАХ</b> .....	18
<b>БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	19
<b>БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТЗҮЙЛС</b> .....	191
<b>БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	19
<b>БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b> .....	21
<b>БҮЛЭГ 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХУДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	23
<b>БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГЫН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ</b> .....	24
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв.....	25

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол.....	3
Хүснэгт 2. Наран голын зүүн дэнжийн алтны шороон ордын (ХШ-102-ХШ-114) нөөц, Сорьц 917. /2020.07.01/ .....	5
Хүснэгт 3. Уулын ажлын төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт.....	7
Хүснэгт 4. Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл.....	8
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ .....	16
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	22
Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	24
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт .....	25

**Зургийн жагсаалт**

- Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг
- Зураг 2. Ил уурхайн ашиглалтаар үүсэх ухаш
- Зураг 3. Элсний биетийн газрын хэвлий дэх тогтоц
- Зураг 4. Талбайн газрын гадарга
- Зураг 5. Талбайн өндөршил

### БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Пентатерра” ХХК-ийн “Наран голын зүүн дэнж ХШ-102-с ХШ-114” алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино.

#### 1.1. Төслийн товч танилцуулга

“Пентатерра” ХХК-ын MV-019039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Наран голын зүүн дэнж ХШ-102-с ХШ-114” алтны шороон ордын талбай нь Сэлэнгэ аймгийн Баянгол (хуучнаар Баруунхараа) сумын нутагт, тус сумын төвөөс зүүн хойд зүгт 60 км, Мандал (хуучнаар Зүүнхараа) сумын төвөөс хойд зүгт 33 км, Дархан-Уул аймгийн Шарын гол сумаас зүүн урд зүгт 19 км зайд тус тус оршино. Байр зүйн зургийн L-48-105, 106 нэрэлбэрт оршиж 37.0 га талбайг хамарна.


Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол

№	Уртгаг	Өргөрөг		Уртгаг	Өргөрөг
1	106° 31' 11.34"	49° 5' 0.41"	32	106° 30' 49.32"	49° 5' 0.3"
2	106° 31' 10.68"	49° 5' 0.54"	33	106° 30' 55.56"	49° 5' 0.3"
3	106° 31' 9.35"	49° 5' 0.92"	34	106° 30' 55.56"	49° 4' 57.6"
4	106° 31' 8.14"	49° 5' 1.36"	35	106° 31' 4.41"	49° 4' 57.6"
5	106° 31' 6.52"	49° 5' 1.38"	36	106° 31' 4.41"	49° 4' 43.89"
6	106° 31' 4.92"	49° 5' 1.54"	37	106° 31' 21.99"	49° 4' 43.89"
7	106° 31' 3.49"	49° 5' 1.78"	38	106° 31' 26.63"	49° 4' 45.76"
8	106° 31' 3.23"	49° 5' 1.85"	39	106° 31' 29.37"	49° 4' 46.46"
9	106° 31' 2.06"	49° 5' 2.13"	40	106° 31' 31.27"	49° 4' 46.64"
10	106° 31' 1.84"	49° 5' 2.2"	41	106° 31' 33.82"	49° 4' 46.61"
11	106° 31' 1.66"	49° 5' 2.25"	42	106° 31' 35.71"	49° 4' 46.17"
12	106° 31' 1.25"	49° 5' 2.38"	43	106° 31' 38.23"	49° 4' 45.29"
13	106° 31' 0.71"	49° 5' 2.55"	44	106° 31' 40.11"	49° 4' 44.44"
14	106° 31' 0.43"	49° 5' 2.65"	45	106° 31' 41.22"	49° 4' 44.21"
15	106° 31' 0.19"	49° 5' 2.73"	46	106° 31' 41.25"	49° 4' 44.21"
16	106° 30' 58.82"	49° 5' 3.25"	47	106° 31' 41.25"	49° 4' 56.47"
17	106° 30' 58.68"	49° 5' 3.3"	48	106° 31' 37.65"	49° 4' 56.76"
18	106° 30' 58.64"	49° 5' 3.31"	49	106° 31' 29.27"	49° 4' 57.37"
19	106° 30' 58.55"	49° 5' 3.35"	50	106° 31' 26.67"	49° 4' 57.55"
20	106° 30' 58.19"	49° 5' 3.5"	51	106° 31' 24.59"	49° 4' 57.74"
21	106° 30' 57.17"	49° 5' 3.91"	52	106° 31' 22.26"	49° 4' 58.04"
22	106° 30' 55.49"	49° 5' 4.7"	53	106° 31' 20.06"	49° 4' 58.43"
23	106° 30' 54.3"	49° 5' 5.38"	54	106° 31' 18.05"	49° 4' 58.93"
24	106° 30' 53.24"	49° 5' 6.07"	55	106° 31' 14.65"	49° 4' 59.94"
25	106° 30' 51.79"	49° 5' 7.16"	56	106° 31' 14.16"	49° 5' 0"
26	106° 30' 50.77"	49° 5' 7.01"	57	106° 31' 13.83"	49° 5' 0.02"
27	106° 30' 50.4"	49° 5' 6.98"	58	106° 31' 12.75"	49° 5' 0.15"

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “НАРАН ГОЛЫН ЗҮҮН ДЭНЖ ХШ-102-114”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

28	106° 30' 50.36"	49° 5' 6.98"	59	106° 31' 12.73"	49° 5' 0.15"
29	106° 30' 50.28"	49° 5' 6.97"	60	106° 31' 12.46"	49° 5' 0.18"
30	106° 30' 49.32"	49° 5' 6.9"	61	106° 31' 12.1"	49° 5' 0.25"
31	106° 30' 49.32"	49° 5' 6.9"	62	106° 31' 11.88"	49° 5' 0.29"

**МУ-019039 тоот дугаартай "Наран голын зүүн дэнж" алтны шороон ордын тойм зураг**



**Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг**

**Уурхайн одоогийн байдал**

“Пентатерра” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2015 оны 08 дугаар сарын 21-ний өдөр авсан бөгөөд 2015 онд хайгуулын ажил явуулж нөөцийн тайланг батлуулан 2016 онд “Наран гол” нэртэй орд ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг батлуулсан байна. Тус компани нь 2016 онд тус ордод олборлолтын үйл ажиллагаа явуулсан бөгөөд 2017 оноос 2020 он хүртэл үйл ажиллагаа явуулаагүй ба 2021 онд тус ордод олборлолтын үйл ажиллагаа явуулсан.

“Пентатерра” ХХК нь 2020 онд “Шарын гол уул уурхай” ХХК-д 25.74 га талбайг хэсэгчлэн шилжүүлсэн бөгөөд үлдэгдэл 37.0 га талбай дээр 2019 онд нэмэлт хайгуулын ажил явуулж, улмаар нөөцийн тодотгол тооцооны үр дүнгийн тайланг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам, Ашигт Малтмал, Газрын Тосны газрын дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитой В зэрэглэлийн 164.52

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “НАРАН ГОЛЫН ЗҮҮН ДЭНЖ ХШ-102-114”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

мян.м<sup>3</sup>, боломжтой С зэрэглэлийн 57.47 мян.м<sup>3</sup>, нийтдээ В+С зэргээр 221.99 мян.м<sup>3</sup> элсний нөөц, 285.96 кг буюу химийн цэврээр 262.19 кг алтны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

*Хүснэгт 2. Наран голын зүүн дэнжийн алтны шороон ордын (ХШ-102-ХШ-114) нөөц, Сорьц 917. /2020.07.01/*


Блокийн дугаар, Нөөцийн зэрэг	Блокийн талбай	Хучаас хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрсний эзлэхүүн	Элсний эзлэхүүн	Дундаж агуулга	Металлын нөөц /Шлих/	Хими цэвэр
Х.нэгж	/мян. м <sup>2</sup> /	/м/	/м/	/мян. м <sup>3</sup> /	/мян. м <sup>3</sup> /	гр/ м <sup>3</sup>	/кг/	/кг/
В-6	1.45	41.60	2.00	60.32	2.90	4.281	12.41	11.38
В-7	7.32	42.60	1.40	311.83	10.25	1.859	19.06	17.47
В-8	7.40	42.80	1.40	316.72	10.06	1.780	17.92	16.43
В-9	4.89	41.70	1.80	203.91	8.80	1.742	15.33	14.06
В-10	7.21	39.70	1.70	286.24	12.02	1.531	18.39	16.87
В-11	7.38	39.00	2.10	287.82	15.87	1.718	27.26	24.99
В-12	7.09	39.60	2.40	280.76	17.18	1.901	32.66	29.94
В-13	8.00	38.80	2.80	310.40	22.01	1.288	28.35	25.99
В-14	10.44	38.30	2.40	399.85	25.06	1.160	29.08	26.66
В-15	10.49	39.40	2.30	413.31	24.13	1.559	37.61	34.49
В-16	7.11	41.60	2.30	295.78	16.25	1.515	24.61	22.57
С-17	0.69	43.10	1.70	29.74	1.15	1.437	1.65	1.51
С-18	18.04	41.80	1.40	754.07	26.06	0.324	8.44	7.74
С-19	15.17	37.40	1.20	567.36	18.81	0.407	7.66	7.02
С-20	9.54	44.90	1.20	428.35	11.45	0.483	5.54	5.07
<b>Нийт (В)</b>	<b>78.80</b>	<b>40.20</b>	<b>2.1</b>	<b>3,166.94</b>	<b>164.52</b>	<b>1.597</b>	<b>262.67</b>	<b>240.84</b>
<b>Нийт (С)</b>	<b>43.40</b>	<b>41.00</b>	<b>1.3</b>	<b>1,781.14</b>	<b>57.47</b>	<b>0.405</b>	<b>23.29</b>	<b>21.35</b>
<b>Бүгд (В+С)</b>	<b>122.22</b>	<b>40.50</b>	<b>1.8</b>	<b>4,947.64</b>	<b>221.99</b>	<b>1.288</b>	<b>285.96</b>	<b>262.19</b>

**1.2. Уулын хэсэг**

**Уурхайн хил хязгаар, үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо**


**Уул-техникийн нөхцөл:** Орд нь уул техникийн харьцангуй энгийн нөхцөлд оршдог. Ордын ашиглалтын хүрээн дэх хучаас хөрсний дундаж зузаан 40.46 м, алт агуулсан элсний дундаж зузаан 2.05 м, дундаж агуулга 1.597 гр/м<sup>3</sup> байна. Газрын гадарга нь урдаасаа хойшоо унасан налуу тогтоцтой. Хуулах хөрсний ихэнх материал нь хайрга, элс, шаварлаг байна.

**Ил уурхайн талбай:** Наран голын зүүн дэнжийн талбайд орших ил уурхайн хүрээний урт ойролцоогоор L=1,067.59 м, хамгийн бага өргөн нь W<sub>min</sub>=106 м, хамгийн их өргөн нь тах=199.5 м, дундаж өргөн нь W<sub>д</sub>=152.75 м байх бөгөөд 15.84 га талбайг хамарсан ухаш үүсэхээр байна.



*Зураг 2. Ил уурхайн ашиглалтаар үүсэх ухааш*

**Ил уурхайн гүн:** Ил уурхайн ёроолын түвшин нь 16-В блокийн +1052.3 м-ээс 6-В блокийн +1029.0 м түвшин хүртэл налуу уналтай байна. Элсний биетийн унал нь газрын гадаргатай параллель буюу газрын гадаргын уналын дагуу тогтсон учир ил уурхайн гүн харьцангуй тогтвортой байх бөгөөд газрын налуугаас хамаараад Уурхайн баруун урд хэсэгт хамгийн их гүн 47 м, зүүн хойд хэсэгт хамгийн бага гүн 40.5, ил уурхайн хэмжээнд дундаж гүн нь 43.8 м байна.



*Зураг 3. Элсний биетийн газрын хэвлий дэх тогтоц*

### **Ордын ашиглалтын нөөцийн тооцоо**

Тус ордыг лицензийн хүрээнд уурхайн хэмжээсүүдийн дагуу уурхайн загварыг гаргахад ашиглах геологийн нөөцөөс ил уурхайн хүрээ хязгаарт хамрагдах нөөцөд хаягдалгүй, бохирдол тооцсоны үндсэн дээр үйлдвэрлэлийн нөөц буюу баяжуулах элсний нөөцийн хэмжээ гаргав. Нөөцийг уурхайн хэмжээс болон ашиглалтын системийн дагуу лицензийн талбай дотор олборлоход ил уурхайн хүрээ хязгаарт 17-С блокийн 1.15 мян.м<sup>3</sup> буюу 1.65 кг буюу 1.52 кг нөөц хамрагдахгүй, мөн 6-В блокоос 0.85 кг буюу химийн цэврээр 0.78 кг нөөц, 7-В блокоос 7.33 кг буюу химийн цэврээр 6.72 кг нөөц, 8-В блокоос 6.21 кг буюу химийн цэврээр 5.69 кг нөөц, 9-В блокоос 3.96 кг буюу химийн цэврээр 3.63 кг нөөц, 10-В блокоос 1.15 кг буюу химийн цэврээр 1.06 кг нөөц, 16-В блокоос 8.22 кг буюу химийн цэврээр 7.54 кг геологийн нөөц хамрагдахгүй бөгөөд нийт (B+C) зэрэглэлийн нөөцөөс 29.38 кг буюу

химийн цэврээр 26.94 кг нөөц хасагдаж байна. Энэ нь нийт геологийн нөөцийн 11.11% эзэлж байна. Ил уурхайн хүрээнд хамрагдах В зэрэглэлийн геологийн нөөц нь 1.583 гр/м<sup>3</sup> дундаж агуулгатай, 148.44 мян.м<sup>3</sup> элс, 234.95 кг буюу химийн цэврээр 215.43 кг алт буюу геологийн нөөцийн 88.89% олборлохоор байна. Ил уурхайн хүрээнд өртөх геологийн нөөцөд үндэслэн үйлдвэрлэлийн нөөц бодоход 18.43%-ийн бохирдолтой, 1.334 гр/м<sup>3</sup> дундаж агуулгатай 176.14 мян.м<sup>3</sup> элс олборлож 235.06 кг буюу химийн цэврээр 215.54 кг алт авахаар байна. Алт агуулсан элсийг хаягдалгүй дунджаар 18.43% бохирдуулж олборлоход дундаж агуулга нь 15.56%-иар буурч 1.334 гр/м<sup>3</sup> болж байна.

### 1.3. Ил уурхайн ашиглалтын систем

**Уурхайн жилийн хүчин чадал:** Төсөл хэрэгжүүлэгч компани нь өөрийн HITACHI EH1200-6, HYUNDAI-R520LC маркийн 2 ширхэг экскаватор, SINOTRUCK HOWO-371 маркийн 7 ширхэг автосамосвалтай болно. Эдгээр тоног төхөөрөмжийг бүтээлийг үндэслэн жилийн хүчин чадлыг оновчлов. HITACHI EH1200-6 маркийн 2ш экскаваторын жилийн бүтээл 1,499,480 мян.м<sup>3</sup> , HYUNDAI R520LC маркийн экскаватор жилийн бүтээл 678.4 мян.м<sup>3</sup> уулын цул хуулах бөгөөд нийт 2,117,880 мян.м<sup>3</sup> уулын цул хуулна. Уурхайн ашиглалтын жилүүдэд олборлох элсний хэмжээ нь уурхайн гадаад ба дотоод овоолгын орон зай болон жилд хуулаххөрснөөс хамааралтайгаар жил бүр харьцангуй өөр байна.

### 1.4.2026 онд явуулах уулын ажил, ажиллах горим

**Ажиллах горим:** Баяжуулалтын технологиос хамааран уурхайн олборлолтын ажлыг улирлын чанартай явуулна. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй, өдөрт 2 ээлжээр 10 цагаар явагдана.

**2026 онд явагдах уулын ажил:** Ашиглалтын жилд 6-В, 7-В, 8-В 9-В, 10-В, 11-В блокуудыг олборлоход ил уурхайн хүрээ хязгаараар тус блокуудаас 43.17 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 56.67 кг байна. Хөрс хуулалтын итгэлцүүр  $K_x \cdot x = 45.4$  м<sup>3</sup>/м<sup>3</sup>

#### Хүснэгт 3. Уулын ажлын төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Материал		Х.нэгж	2026 он
Хөрс	Шимт хөрс	м <sup>3</sup>	20,000.0
	Хөрс	м <sup>3</sup>	1,960,000.0
	Нийт	м <sup>3</sup>	
Элс	В нөөц	м <sup>3</sup>	43,170.0
		м <sup>3</sup>	
	Нийт	м <sup>3</sup>	-
Уулын цулаар		м <sup>3</sup>	
Хөрс хуулалтын итгэлцүүр		м <sup>3</sup> /м <sup>3</sup>	45.4
Гадаад овоолго	Цулаар	м <sup>3</sup>	
	Сийрэгжсэн	м <sup>3</sup>	
Дотоод овоолго	Цулаар	м <sup>3</sup>	2,003,170.0
	Сийрэгжсэн	м <sup>3</sup>	2,203,487.0

**Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд:**

Энэ жил “Пентатерра” ХХК нь тоног төхөөрөмжийн сонголтод өөрийн техникүүдээ ашиглахаар техникийн даалгаварт тусгасан. Тус техникүүдийн иж бүрдэл, техникүүдийн тоо ширхэг болон хүчин чадал уурхайг ашиглахад хүрэлцээтэй мөн техникийн хослол таарч байгаа. “Пентатерра” ХХК-ны уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн иж бүрдэл болонажлын зориулалтыг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 4. Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл*

№	Ажлын зориулалт	Марк	Тоо, ш
1	Хөрс хуулалт	HITACHI EH1200-6	2
2	Хөрс ба элс олборлолт	HYUNDAI R520LC-95	1
3	Хөрс болон элс тээвэрлэлт	SINOTRUCK HOWO-371	7
4	Хөрс тээвэрлэлт	HITACHI 1700	2
5	Хөрс тээвэрлэлт	CAT773E	3
6	Овоолго, зам талбай	CAT-D8R	1
7	Туслах ажил	LIUGONG CLG855H	2
8	Талбайн ул цэвэрлэх, зам түрэх	LIUGONG CLG4215	1
9	Ус соруулах	K75	2
<b>Нийт</b>			<b>20</b>

**1.5. Уурхайн нөхөн сэргээлт**

2026 онд олборлолтын ажилтай зэрэгцэн дотоод овоолго болон нөхөн дүүргэлтийн системтэйгээр 6.4 га талбайд 16-В, 14-В, 15-В блокуудад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ. 11-В, 12-В, 13-В блокуудад биологийн нөхөн сэргээлт мөн өмнө эвдэрсэн 5.8 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийхээр байна.




*Зураг 4. 2026 оны уулын явагдах талбай*



Зураг 5. 2026 онд техникийн нөхөн сэргээлт хийгдэх талбай 6.4 га



Зураг 6. 5.8 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдэнэ.



Зураг 7. Урд жилүүдийн нөхөн сэргээлт

### **1.6. Баяжуулалтын технологи**

Ил уурхайн элс олборлолтын төлөвлөгөө болон “Пентатерра” ХХК-ны элс угаан баяжуулах төхөөрөмжийг уурхайн баруун талд байхаар төлөвлөв. Элс олборлолтын дараа үлдсэн орон зайд баяжуулах хэсгээс гарсан эфель, гаалийн хаягдлыг зөөн нөхөн дүүргэхээр төлөвлөсөн. Технологийн схемийн хувьд шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулахад 0.11%-ийн гарцтай 1460 мг/м<sup>3</sup>-ийн алтны агуулгатай 92 %-ийн металл авалттай баяжмал гаргана.

### **1.7. Дэд бүтэц**

#### **Цахилгааны хангамж.**

Уурхайн цахилгаан хангамж нь төвийн эрчим хүчтэй холбогдоогүй байгаа тул ашиглалтын жилд цахилгаан үүсгүүр ашиглана.

#### **Шатах тослох материалын агуулах.**

Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээрхангана. Түлшний агуулах нь 50,000 литр түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж гүйцтэгэнэ.

#### **Уурхайн гадаргуугийн байршил.**

Уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөгөөнд уурхай, үржил шимт хөрсний овоолго, уурхайн хотхон, угаах төхөөрөмж, цэвэр бохир нуурын байрлал, авто зам зэрэг барилга байгууламж орно. Уурхайн хотхон, баяжуулах хэсгийн талбайг уурхайтай ердийн замаар холбоно.

## **БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ**


Баянгол сумын нутаг дэвсгэр зүүн урдаасаа баруун хойшоо Хараа гол, түүний хөндий, хойд хэсэгтээ зүүнээсээ баруун тийшээ Хараа хүртэл Баянголын хөндийгөөр хэрчигдсэн бэсрэг уулсын системээс тогтсон гадаргуутай. Тус сумын нутаг дэвсгэрийн газрын гадаргын хувьд: Баянголоос хойш орших уудам ам хөндий, бэсрэг уулс, ухаа толгод бүхий гадаргатай хэсэг. Хараа, Баянголуудын хоорондох өргөн, нарийн ам, хөндийнүүдтэй харьцангуй өндөр болон, бэсрэг уулс бүхий гадаргатай хэсэг. Хараа голын урд болон баруун талд байгаа ам хоолой

бүхий бэсрэг уулс, ухаа толгод бүхий гадаргатай хэсэг гэсэн үндсэн 3 хэсэгт хувааж болно.



*Зураг 8. Талбайн газрын гадарга*

### Талбай орчмын өндөршил



Зураг 9. Талбайн өндөршил

**Гадаргын ус:**

Эрлийн ажил хийгдсэн талбайд Хараа гол, түүний зүүн баруун цутгалууд Баянгол, Дарьт, Шивэрт, Түнхэл, Шарын гол, түүний баруун, зүүн цутгал Буянт, Хүйтэн, Шаазгайт, Хавчуу, Хуурай зэрэг байнгын урсгал устай томоохон голуудын сүлжээ орох бөгөөд тэдгээрийн цутгалууд болох Шивэрт, Могойт, Тариат, Ноёнт, Шаазгайт, Наран зэрэг олон жижиг голууд цутгадаг. Эдгээр байнгын урсгалт голуудаас хамгийн том нь Хараа, Шарын гол юм. Хараа гол нь судалгаа хийгдсэн талбайд 100 гаруй км урт, 25м өргөнтэйгөөр цааш үргэлжилдэг бол Шарын голын урт 70 гаруй км, голын голдирлын өргөн 5.0м, гүн нь 0.6-1.0м, усны зардал 8-25л/сек хүрдэг. Голуудын усны урсгал тогтуун 0.5-0.8м байх ба голын голдирол зарим хэсэгтээ огцом тохойрсон нь ажиглагдана. Хараа, Шарын голуудын зүүн баруун болох дээр дурдсан гол, горхи нь 5-30 гаруй км урттай байх ба голдирлын өргөн 0.4-5.0м, гүн нь 0.4-2.0м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Шарын голын зүүн баруун цутгал Буянт, Хуурай, Хавчуу, Шаазгайт тэрчлэн Шивэртийн голуудын усны зардал ихэвчлэн  $0.6\text{м}^3/\text{сек}$  хүрдэг. Хараа голын цутгалын нэг болох Баянголын эх, Нарангийн гол, түүнд цутгадаг Урт булгийн горхи урсдаг.

Нарангийн гол нь 20км урттай, 1.3м өргөнтэй, 0.5-1м гүнтэй бол Урт булгийн горхи нь 4-5км урттай, 0.5-1м өргөнтэй, 0.2-0.3м зарим үед 0.8м хүртэл гүнтэй урсгал түргэнтэй горхи юм. Эдгээр горхинууд нь  $0.5-0.8\text{м}/\text{сек}$  хурд бүхий урсгалтай, зардал нь  $0.6-1.0\text{м}^3/\text{сек}$  хүрдэг байна. Нарангийн гол болон Урт булгийн горхины татмын хэсэг нь нэлээд усархаг бөгөөд зарим үед намгархаг шинжтэй байдаг.

**Талбайн хөрсөн бүрхэвч.** Зарим тохиолдолд уулын ам хөндий болон томоохон голуудын бэлчир, эрэг дэнж орчмоор ой, төгөл ой тархдаг. Ялангуяа Орхон - Сэлэнгийн бэлчир, Сэлэнгэ, Улз голын хөндий зэрэг газруудаар сийрэг ой тохиолддог. Ихэвчлэн голын үйл ажиллагааны нөлөөгөөр хуримтлагдсан элсэн хурдас дээр тогтворжсон онцлогтой тул угаагдал эрчимтэй явагдаж, угаагдлаар хөрсөнд агуулагдах эрдэс бодис алдагддаг тул чандруулаг хөрс хэмээн ялган үздэг. Энэ хэв шинжийн хөрсний гол онцлог нь хучаас үеийн дор залган органик бодисын бараан хүрэн толбуудтай, сааралдуу өнгөтэй, цайвар бор өнгийн толбо судал бүхий чандруулаг давхарга тод ялгардаг.

Ой бүхий газарт уулын ойн ширэгт бараан хөрс тохиолдох бөгөөд ихэвчлэн уулын ар хажуугийн ойтой хэсэгт бүхэлд нь тархана. Түүхэн хөгжлийн явцад ой ашиглалт болон ой тэлж ургах, үүсэх үйл явцтай холбоотойгоор хөрсний хэв шинж, түүний шинж чанар болон ургамлын нөмрөг хувьсан өөрчлөгдсөөр иржээ.

Ойн ширэгт хөрс нь ихэвчлэн уулархаг, ойгоор хучигдсан нутгаар 800- 1700 метр өндөрт тархах бөгөөд цэвэр болон холимог шинэсэн, нарсан, хусан ойд элбэг тохиолддог. Ойн ширэгт хөрсний гол онцлог нь ялзмагт давхарга тод ялгарсан, ширэгт давхарга хөгжсөн, бөөмөрхөг үрлэн бүтэцтэй, чийгийн хангамж өндөр учир сулавтар хүчиллэг урвалын орчинтой, шингээгдсэн сууриудаар бүрэн ханасан, шаварлаг хурдсанд глейжилт бүдэг илэрдэг явдал юм.

**Ургамал.** Тус талбай нь монгол орны ургамал газарзүйн мужлалаар Монгол дагуурын уулын хээрийн тойрогт хамрагдаж байна (Өлзийхутаг,1983). Монголын нэрт ургамал судлаач, академич Н.Өлзийхутаг “Монгол орны ургамлын аймгийн тойм” (1982) бүтээлдээ тус нутгийг монгол орны ургамал газарзүйн мужлалаар Монгол Дагуурийн хээрийн тойрогт хамруулан авч үзсэн байдаг. (Өлзийхутаг,1982).

**Амьтны аймаг.** Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны амьтны аймгийн газар зүйн

